

**“1910 - 1919 ОНЫ БЭЭЖИН-ХҮРЭЭНИЙ УЛС ТӨРИЙН
ХАРИЛЦАА” СЭДЭВТ МОНГОЛ-ТАЙВАНИЙ ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ**

*Б.БАЛДОО**

Монгол улсын ШУА, Тайваний Монгол-Төвдийн хорооны ивээн тэтгэлгээр Монгол Улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Хятадын Үндэстний судлалын нийгэмлэг /Тайвань/ хамтран 2000 оны 12-р сарын 16-нд “1910-1919 оны Бээжин-Хүрээний улс төрийн харилцаа” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохиов.

Бага хуралд Тайваний Дунхуа их сургуулийн Үндэстний харилцаа болон соёл судлах хүрээлэнгийн профессор, Тайваний Үндэстний судлалын нийгэмлэгийн дарга асан Цяо Зянь тэргүүтэй төлөөлөгчид, манай хүрээлэнгийн болон бусад их, дээд сургуулийн эрдэмтэн судлаачид оролцож, монголын талаас 8 илтгэл, тайваний талаас 5 илтгэл /нэг илтгэлийг товчлолоор эчнээ/ тавьж, илтгэл тус бүрд нэг нэг шүүмжлэгч томилон илтгүүлж эцэст нь санал солилцон, хэлэлцэх журмаар бага хурлыг явуулав.

Энэ бага хурал тус ОУСХ-ээс Тайваний эрдэмтэн-түүхчидтэй хийж буй анхны хурал болов. Урьд Тайваний эрдэмтэн-түүхчдийн Монгол-хятадын харилцааны асуудлаар хийсэн судалгааны үр дүнг харуулсан илтгэл өгүүллийг ийм хэлбэрээр бид сонсч байгаагүй тул Тайваний судлаачдын тавьсан дөрвөн илтгэлүүдийн гол санаа, дүгнэлтийг товчлон авч ямар нэгэн үнэлэлт үгүйгээр тоймлон бичив.

Бага хурлын төлөвлөгөөнд тусгасан сэдвээр тавигдсан Тайваний судлаачдын илтгэлүүд үндсэндээ хятадын эрдэмтэдийн баримталдаг ерөнхий байр сууринаас бичигдсэн, тухайлбал Манж Чин гүрний шинэ засгийн бодлого бол Монголд хэрэгтэй зүйл байсан юм, гэвч Манжийн Засгийн газар зохих ёсоор хэрэгжүүлж чадаагүй, Монгол Манж Чин гүрний, тодорхой хэлбэл “Хятадын тэнгэрийн хаанчлалын” бүрэлдүүн хэсэг байсан юм, Монгол Хятадтай хамт байх нь ашигтай байсан юм, Монголын тусгаар тогтнолд Оросын өдөөлт голлох үүрэг гүйцэтгэсэн юм гэх мэт санаанууд олонхи илтгэлд улаан шугамаар гарч байна.

Тэгэвч Тайваний түүхчдийн бэлтгэсэн илтгэлүүд хятадын архив, хятад болон бусад орны судлаачдын бүтээл, оросын тухайн үеийн баримт материалын Хятадад орчуулагдсан эмхэтгэлийн материал, өгөгдхүүн зэрэг дээр үндэслэн бичигдсэн байна. Зарим

* Б.Балдоо - Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, академич

илтгэлд монгол судлаачдын зохиолоос ишилсэн зүйл цөөн ч гэсэн байна. Олонхи илтгэл сонирхолтой бичигдсэн, анхаарч үзвэл зохих тоо баримт, дүгнэлт гаргалгаатай болсон гэж үзэлтэй. Илтгэл тус бүрд тэр үеийн түүхнээ болсон үйл явдлуудыг давтан хэлж, өөр өөрийн илтгэлийн аспектаа илэрхийлэхийн тул давтамжийг ашигласан талтай.

Богино хугацаанд илтгэлүүдийг Монголд орчуулсан тул цаашид орчуулгыг дахин хянаж нэр томъёо, найруулгын талаас сайжруулах шаардлагатай.

Тайваний талаас тавьсан илтгэлүүд:

1. "1911 оны Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөний шалтгааныг шинжлэхүй" -дэд профессор Лань Мэйхуа;

2. "Дундад иргэн улсын эхэн үед Гадаад Монголын тусгаар тогтнол Өвөр Монголын улс төр, эдийн засагт нөлөөлсөн нь" -дэд профессор Хуан Лишэн;

3. "Хүрэн дэх Хятадын шинэ бодлого ба түүний ялагдлын шалтгааныг судлах нь" -докторант Чэнь Вэйсинь;

4. "Автономиос автономии алдах хүртэл" -дэд профессор Лю Сюеяо (товчлолоор эчнээ);

5. "Нармай Монголыг байгуулах гэсэн хөдөлгөөн: Халхын тусгаар тогтнолын талаарх өөр үзэл" -профессор Жан Жисюн эдгээр болно.

Одоо илтгэл тус бүрд илтгэн гаргасан гол санаа, дүгнэлтүүдийг тоймлон авч үзье.

Улс төрийн их сургуулийн угсаатны тэнхимийн дэд профессор Лань Мэйхуа "1911 оны Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөний шалтгааныг судлах нь" илтгэлдээ Монгол Манж Чин улсын ноёрхолд орсноос хойшхи үеийн Манж-Монголын харилцаа, Манжийн төрийн монголын талаарх бодлогыг судалж, Монгол яагаад 220 жилийн дараа тусгаар тогтнолоо зарлах болсон юм, Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн гарах болсон учир шалтгаан юу байсан юм гэдгийг тодруулан түүнийг анхдагч шалтгаан, шууд шалтгаан, хамгийн эцсийн буюу ультимат шалтгаан гэж гурав хуваан үзэж, баримт сэлт татан тэдгээрийг үндэслэсэн байна. Судлаачийн үзсэнээр анхдагч шалтгаан нь монголын эдийн засгийн уналт, манжийн төрийн түшмэдийн чадвар мөхөс байдал; шууд шалтгаан нь Манжийн төрийн Монгол дахь бодлогын өөрчлөлт, Сандо ба Тан Зайли зэрэг хүмүүсийн засаглал; эцсийн шалтгаан нь Манж Чин гүрний мөхөлт хэмээн тодорхойлогдох ажээ.

Тэрбээр илтгэлдээ Монгол нутгийн эдийн засгийн уналт, Сандо зэрэг хүмүүсийн явуулсан бодлого, Чин гүрний мөхөл, Орос улсын үүрэг, Монголд Манжийн эсрэг тэмцэл өрнөсөн нь гэх зэрэг асуудлуудыг задлан шинжилж сонирхол татах гаргалга, дүгнэлтүүд

хийсэн байна.

Монголд ноёрхлоо тогтоосноос хойших үеийн Манж Чин гүрний бодлого, түүний хувиралт өөрчлөлт болон Монголд үзүүлсэн нөлөөг авч үзжээ.

Монголд манжийн ноёрхол тогтсоны эдийн засгийн том үр дагаварын нэг нь хятад худалдаачид их хэмжээгээр орж ирсэн явдал юм. Чин улсын явуулсан худалдааны цогц бодлогоор зөвшөөрөлтэй орж ирсэн хятад худалдаачидад зөвшөөрсөн хугацаанаас илүү байх, байшин барилга барих, монгол эхнэр авах, их хэмжээгээр мөнгө зээлдэхийг хориглосон байв. Яваандаа худалдаачдын тоо эрс өсч монгол ноёдтой сүлбэлдсэн зэргээс хяналт тавих бололцоо хумигдсан байна. Энэ худалдааны бодлогын дүнд монголчууд хятадын худалдаачид, мөнгө хүүлэгчдэд их хэмжээний өр төлбөртэй болсон /3-р тал/ гэжээ.

Манжийн засгийн газар Монголын малчин ардуудад олон төрлийн алба гувчуурыг оногдуулдаг байсны хамгийн хүнд нь хилийн харуул, өртөөний алба байв. Үүнээс гадна манжийн засаг захиргааны, Манжийн хаанд барих өргөл барьцын, Монгол дахь цэргийн хангамжийн гэх мэт зардлыг монголчууд гаргадаг байсны дээр манж нар ардын эд хөрөнгийг дээрэмдэх, элдэв нэмэгдэл татвар авдаг болжээ. Энэ бүхний үр дүнд “монгол түмний амьдрал доордож, Манж Чин улсын дарлалын эсрэг дүргүйцэл улам нэмэгдэх болжээ” /5-р тал/ гэж судлаач бичиж, олон тооны тоо баримт дурдан, нэлээд судлаачдын зохиол бүтээлээс ишилсэн байна.

Судлаачийн үзснээр улс төрийн хувьд манжийн бодлого яваандаа өөрчлөгдөж “Зүүн гарын бослого намжсаны дараагаас Чин улсын засгийн газар манж маягийн төрийг хятад маягийн төрөөр” /5-6 тал/ сольсныг тэмдэглэв. Үүний дүнд монголчуудад хандах хандлага, тэдний талаар явуулах бодлого өөрчлөгдөж, манж монгол нарын “хамтран ажиллах тэгш эрхтэй харилцаа, захирах захирагдах харилцаа болон хувирч”, монгол ноёдын “эрх ямба аажимаар үгүй болж”, тэд “дээд төвшиний бодлогод оролцохгүй” болж, Монгол дахь “манж, хятад түшмэдийн хүч нөлөө нэмэгдсэн” /6-р тал/; үүний нөгөөтэйгүүр “Чин улсын сүүлийн үеийн ноёд түшмэд ялзралд” автагдаж “албан тушаал худалдах, хээл хахууль авах, санг тонох болсныг” дурдаж, энэ бүхэн нь “монголчуудын доройтох”, тэдний “манжийн эсрэг үзэл бүрэлдэх” нэг шалтгаан болсон /6-р тал/ гэж дүгнэжээ.

Судлаач Манжийн төрийн шинэ Засгийн бодлогын (ШЗБ) тухай өгүүлсэн хэсэгтээ “...Монголыг колоничлон авах явдал шинэ бодлогын гол зорилт болов” гэжээ. Энэ бодлого эхлээд Өвөр Монголд явагдаж маш олон хятад иргэн ирж газрыг их хагалбарласныг судлаач

харуулаад “гадаад монголчууд Өвөр монголын хөгжлийг ажиглан харж колонист шинжтэй энэ бодлого нь тэдэнд ямар эмгэнэл, хор уршиг авчрахыг тааварлаж байлаа” (11-р тал) гэж дүгнэсэн байна.

Хүрээнд ШЗБ-ыг хэрэгжүүлж байсан Манж амбад Янь Жи ба Сандогийн үйл ажлыг харуулахдаа Янь Жигийн зөөлөн арга барилыг Сандо хатуу идэвхтэй аргаар сольсныг монголчууд үл таашаан дургүйцлээ илэрхийлж, огцруулахыг шаардаж байсныг дурьдсан байна.

Судлаачийн өмнө дурьдсан зүйлс нь удаан хугацаанд монголчуудын дургүйцэл, эсэргүүцлийг төрүүлж, Манж, хятадаас холдон ангижирч, тусгаар тогтнолоо эгүүлэн олох эрмэлзлэлийг тэдний дунд бий болгож бэлтгэсэн анхдагч ба шууд хүчин зүйлс мөн болохыг харуулах гэсэн оролдлого гэж үзэлтэй юм.

Илтэлийн сүүлчийн хэсэгт Манж Чин улсын мөхөл, түүгээр нөхцөлдсөн хүчин зүйлс нь Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөнийг идэвхжүүлэн амжилтад хүргэснийг тодорхойлжээ.

Монголын тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөн нь 1911 оны Хятадын хувьсгалаас өмнө өрнөсөн хэдий ч уг хувьсгал монголчуудын тэмцэлд ихээхэн нөлөө үзүүлж, түүнийг амжилтанд хүрэх боломжийг нөхцөлдүүлсэн гээд “Хятадын дотоодын хувьсгал нь монголчуудад Манжийн дарлалыг түлхэн унагааж, тусгаар тогтнолоо сэргээх боломжийг өгөөд зогсоогүй мөн тэмцлийн үлгэр дууриал болж байв” (15-р тал) гэж Лань Мэйхуа үнэлж байна.

Үүний хамт Хятадын хувьсгалын уриа лоозон дахь түрэмгийлэгчдийг хөөн зайлуулж, хятад үндэстнээ сэргээн мандуулах гэсэн зүйлийг монголчууд өөрсдийн нь эсрэг уриа хэмээн үзсэн ба мөн түүнчлэн манж гүрэн задран унахад хүрвэл өмнөх бүх хууль зарлиг дахин хүчин төгөлдөр болно гэсэн Монгол Манжийн тохиролцоо байсан гэдгийг болон түүний санааг Гадаад Монголын тусгаар тогтнолыг зарласан тунхаг бичигт тусгасныг зохиогч дурдан тэмдэглэсэн (15-16-р тал) байна.

Лань Мэйхуа Монголын тусгаар тогтнолын үйл хэрэгт Орос улсын оролцооны талаар нэлээд тодорхой дурдав. Тэр бичихдээ “Хятадын олон судлаачдын үздэг шиг Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн нь Орос орны өдөөн хатгалгаар үүсээгүй, монголчууд өөрсдөө тэмцэл өрнүүлсэн билээ. Гэвч энэ нь Оросууд Гадаад Монголд санаархдаггүй байсан гэсэн үг биш юм. Оросын хувьд Гадаад Монгол нь стратегийн чухал ач холбогдолтой тул тэд энэ газар нутгийг сонирхон санаархах нь ойлгомжтой” (16-17-р тал) гэжээ. Зохиогч Монгол дахь Оросын улс төр, эдийн засаг, шинжилгээ судлагааны үйл ажиллагаа, 1911 оны тусгаар тогтнолын хөдөлгөөний талаар Монгол-Оросын харилцааны баримт сэлтийг дурьджээ. Орос улс

Монголыг тусгаар улс болгон зөвшөөрөхөөс татгалзсан бөгөөд түүний нэг шалтгааныг “Монголын тусгаар тогтнолыг дэмжсэнээр Гадаад Монголын Засгийн газраа эмхэтгэн байгуулах хүнд хүчир ажлаас үүрэлцэж Оросын талаас ихээхэн хүч, хөрөнгө шаардагдах болохоос эмээж байлаа” (19-р тал) гэж үзсэн байна.

Лань Мэйхуа Монголын асуудалд Оросын оролцооны талаар хэд хэдэн санаа дүгнэлт хэлжээ.

-Орос Гадаад Монголын тусгаар тогтнолыг дэмжээгүй ч тэд автономит эрх олж авахад үнэхээр тусласан. Энэ нь Хятад болон бусад орныг Монголын дотоод хэрэгт оролцох боломжгүй болгох байв. Иймээс ч Орос зуучлагч зохицуулагчийн үүрэг гүйцэтгэж, дундаас нь ашиг олохыг эрмэлзсэн (19-р тал) юм.

-Чин гүрний хүчин мөхөсдөхөд монголчууд энэ боломжийг ашиглаж тусгаар тогтнолоо олохыг эрмэлзсэн нь дамжиггүй. Иймээс Гадаад Монгол тусгаар тогтнолоо олохын тулд Орос орны дэмжлэг авах шаардлагатай байв.(21-р тал).

-Хүчирхэг гүрнүүд Хятадад нөлөөгөө тогтоох өрсөлдөөний дүнд Гадаад Монгол Оросын нөлөөнд орж, бусад гүрнүүд Гадаад Монголын хэрэгт Оросын зөвшөөрөлгүйгээр оролцохыг больжээ. (21-р тал).

-Монголд 40 гаруй жил Оросын консулаар ажилласан Я.Шишмаревын үйл ажиллагааны тухай, тэр нь үнэнч шударга, Монгол, Хятадын ард түмний хүндэтгэл хүлээсэн хүн болох тухай Хүрээн дэх Манж амбаны тодорхойлолтоос ишилсэн (17-р тал) байна.

Лань Мэйхуа судалгааныхаа төгсгөлд дээрх бүх явдлуудаас үзвэл “1911 оны Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн нь зүгээр нэг хэрэг явдал биш, харин удаан хугацаанд хуримтлагдсан дургүйцлийн бодит үр дүн юм гэдгийг харуулав” гэж дүгнэсэн байна.

Тайваний Хайян улсын их сургуулийн түүхийн салбарын дэд профессор Хуан Лишэн “Дундад иргэн улсын эхэн үед Гадаад Монголын тусгаар тогтнол Өвөр Монголын улс төр, эдийн засагт нөлөөлсөн нь” илтгэлдээ Хятадын “тэнгэрийн доорх эзэмшлийн” үе, Манж Чин улсын шинэ засгийн бодлого, хэрэгжилтийн үе, ДИУ-ын эхэн үе, Ар Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөний үе гэх мэт хөгжлийн үеүд болон Хятад-Оросын харилцаан дахь Өвөр, Ар Монголын тухай өгүүлэн, өөрийн судалгаа, дүгнэлтүүдээ илтгэн гаргасан байна.

Илтгэлийнхээ эхэнд Хятад дахь Юань гүрний ноёрхол эцэс болж, монголчууд тал газартаа эргэн ирсний дараа тэд их говийн өмнөх, хойдох хэсэгт хуваагдан Өвөр, Ар Монголыг бүрэлдүүлэн буй болгосон. Эхлээд Өвөр Монгол, дараа нь Ар Монгол Чин улсын

эзэмшилд шилжсэн. Тэд улмаар хятадын төрт ёсны тогтолцооны (ХТЁТ) хүрээн дэхь “тэнгэрийн доорх эзэмшилд” багтах болсон (энд тэнгэрийн доорхи эзэмшил гэдэг түүхэн ойлголтыг тайлбарлажээ.1-2 тал) гэх мэт үйл явдлыг дурьдав.

Хар тамхины дайны дараа Хятад өрнөдийн орнуудын хүчирхийлэлд өртөн хөрөнгөтний дэлхийн эдийн засгийн систем (ДЭЗС)-ийн “зах хязгаар” болон хувирсан. Манж Чин улс өөрийгөө аварч, оршин тогтнохын тулд шинэ Засгийн бодлого (ШЗБ) хэрэгжүүлсэн. Энэ бодлогыг хэрэгжүүлэх явцад Монгол нутагт мужийн захиргаа байгуулах, бэлчээр нутгийг хагалбарлах болсонд монголчууд хамгаас илүү дургүйцэн эсэргүүцсэн (3-р тал) гэжээ.

Чин улс сулран задрав. Ийм нөхцөлд Гадаад Монголын тусгаар тогтнол, Өвөр Монголын улс төр, эдийн засгийн өөрчлөлт нь “Хятадын тэнгэрийн доорх дэг журмыг бүрэлдүүлж байсан уламжлалт тогтолцоог устгаж чадахуйц үйл явдал болсон” (3-р тал) гэж судлаач үнэлсэн байна. Өвөр, Ар Монгол тухайн үеийн улс төрийн байдалд хандах үйлдэл нь ижил төстэй байгаагүй ч харилцан нөлөөлөн хөгжих явцад газар нутгийн байршил, сонгох сонголт нь өөр өөр болж, тэднийг холбох салгах асуудлууд гарч байсныг дурьджээ.

Ар Монгол дахь хятад оросын хүчнүүдийн нөлөөлөл хэлбэлзэлтэй байсан гэж зохиогч тэмдэглээд Ар монголын талаархи тэдний санаа бодлыг дэлгэрэнгүй гаргажээ.

Европын том гүрнүүдэд шахагдсан Орос улс бодлогын чиглэлээ өөрчилж, Дундад Ази ба Хятад руу нөлөөгөө хүчтэй болгосон гээд Ар Монголд явуулсан бодлого, үйл ажиллагааг нь авч үзээд Манж Чин улс, Орос улсын үйл ажиллагааг харьцуулан үнэлсэн байна. “Ар Монголын тусгаар тогтнол ба түүнд Өвөр монгол цэргүүд оролцсон нь Орос улс Хятадын хойд хязгаарыг өөрийн хил хязгаар болгох гэсэн колонийн бодлогын үр дүн мөн” (4-р тал) гэж дүгнээд тэрхүү колоничлох үйл ажиллагааг (орос худалдаачид, шинжээчдийг ирүүлсэн, тэд хань үндэстэн монголчуудыг устган үгүй хийнэ гэсэн ухуулга хийсэн, Ар Монголыг оросчилох ажил гүйцэтгэсэн гэх мэт) дэлгэрэнгүй дурдаад ийнхүү “Монголын тусгаар тогтнолын асууллаар Орос улсаас өмөг түшиг хайхад хүргэх урьдчилсан нөхцөл бэлтгэсэн” (6-р тал) гэж зохиогч дүгнэв.

Чин улс Богдол хүндэтгэл үзүүлэхгүй болсон, удаан хугацаанд түүнд өргөмжлөл шагнал олгоогүй, Богдын ордны зардлыг хассан зэрэг нь “Богд Жавзандамба Чин улсаас нүүрээ буруулахад нэмэр болсон”, Богд ч Чин улсын ёс гуримыг зөрчин ойшоохгүй болсныг дурьджээ.

“...Чин улс сүүлийн үедээ улс төрийн ялзралд өртөж, түшмэл сайдуудын явдал бурангуй, ...илбэн засах бодлого нь үр дүнгүй болж,

монголчуудын итгэлийг алджээ” (7-р тал) гэсэн байна.

Зохиогч дээр дурьдсаныг үндэслэн “Орос улс монголчуудыг өөртөө татахыг чармайн байхад Манжийн төр сүүл хавьдаа монголчуудыг ойшоохгүй болсон” гээд Ар Монгол Хятадаас тусгаарлах санаа өвөрлөх болсон нь Чин улс үл тоомсорлон, зохисгүй бодлого явуулсантай холбоотой” (6-р тал) гэв.

Манжийн шинэ засгийн бодлогын талаар судлаач дурьдахдаа энэ бодлого Монголын дээд, доорд давхрааны эргэлзлэлийг төрүүлсэн; энэ бодлогын талаар Чин улс, Ар Монгол хоёр нэг байртай байж чадаагүй; энэ бодлого Өвөр монгол болон бусад зах хязгаар нутагт дэвшил хөгжлийн билэг тэмдэг болсон бол Хүрээний хувьд “тэнгэрийн доорхи” тогтолцоо суларсан үед түүний “сүүлчийн баганыг нураах мэт байв” гээд ШЗБ нь “Хүрээнд эх монголчуудын тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөнийг эрчимжүүлэх шалтгаан” болсон гэж үнэлэв. Зохиогчийн бас нэг тэмдэглэсэн зүйл бол Чин улсын засаглалд дургүйцсэн монголчууд дэлхий ертөнцийн өөрчлөлтийг ойлгохдоо ганц талыг баримталж, Орос улс бол Ар Монголын цорын ганц гарц гэж үзсэн, ШЗБ-ын талаар Орос Ар Монгол хоёр нэг байр суурьтай байсан (9-р тал) гээд ийм байдалд монголчуудад нэг л ойлголт байсан, тэр нь хятадаас салж, оросоос тусламж гуйж, “Монгол өөрийн замаар замнах явдал зайлшгүй боллоо” (10-р тал) гэсэн дүгнэлтэнд хүрсэн явдал юм гэжээ. Дээр дурдсан бүхэн эцсийн эцэст Ар Монголын ноёд лам нарыг 1911 оны 7-р сарын 10-ны нууц зөвлөлгөөнд хүргэсэн (11-р тал) гэдэг санааг зохиогч илэрхийлсэн байна.

Ар Монгол Орос хандан тусламж гуйсан тухай, Оросын хандлагын тухай, Хятад дахь Синьхайн хувьсгалын дараа Ар Монгол тусгаар тогтнолын төлөө идэвхтэй хөдөлсөн тухай түүхэн баримтуудыг дурдан дэлгэрэнгүй өгүүлжээ.

Зохиогч Хүрээнд зарласан тусгаар тогтнолын талаар Оросын баримталсан байр суурийг илэрхийлсний дараа Орос улс яваандаа “Монголын тусгаар тогтнолын асуудлыг Хятадын дотоод хэрэгт оролцох хэрэгсэл болгон хувиргасан”, тэгэхдээ тухайн үеийн олон хүчин зүйлийг харгалзан үзээд энэ талаар “санаачилгыг гартаа аваагүй”, Монголын тусгаар тогтнолын хэрэгт “цэрэг гарган оролцоогүй” (12-р тал) юм гэв. Орос улс дипломат болон албан бус шугамаар Ар Монголыг Хятадаас тусгаарлахыг дэмжих байр суурь баримталж, улмаар Гадаад Монголын ашиг сонирхлыг илэрхийлэгч хүч мэт сэтгэгдлийг бий болгосон юм. Энэ байр суурь нь хожмын өдөр Монголын тусгаар тогтнолын асуудлыг зохицуулан шийдвэрлэхэд, Хятадтай хэлэлцээ хийхэд “хамгийн зөв шийдэл” (12-р тал) болсон гэж судлаач үнэлжээ.

Хятадад Синьхайн хувьсгал гарч, тэнд төр солигдоход Ар

Монгол Хятадын шинэ засгийн гарт орохыг үл хүсэн тусгаар тогтнолын төлөө идэвхтэй хөдөлсөн үйл явцыг илтгэлд дараалан харуулж, “Улиастай, Ховдыг чөлөөлөх үйл явцад Өвөр Монголын цэрэг оролцсон” нь “Ар Монгол тусгаар тогтнож байсныг гэрчилж байна” (13-р тал) гэж үзэв. Чөлөөлөх хөдөлгөөн эхэлж байхад Монголыг хамрах хандлагатай байсан тусгаар тогтнолын төлөө өрнөсөн цэргийн үйл ажиллагаа сүүлдээ өргөжиж Өвөр Монгол хүрсэн юм (13-14-р тал) гэсэн байна.

Ар Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн Өвөр Монголд нөлөөлсөн нөлөөлөл, Өвөр Монгол дахь Удай вангийн хөдөлгөөн, Өвөр Монголын талаар Орос улсын баримтлал зэргийг илтгэлд өгүүлжээ. Энэ хэсэгт Орос улс өөрийн бодлогын талаар: Ар, Өвөр Монгол нэгдэн тусгаар тогтнох асуудал маш нарийн төвөгтэй. Ар Монголын тусгаар тогтнол нь маш хэврэг бөгөөд Өвөр Монголтой нэгдэхэд улс төрийн хямрал үүсч болзошгүй гэж тэмдэглэсэн зүйлийг иш татсан байна.

Өвөр Монголын ноёдын байр суурь, түүний өөрчлөлтийг илтгэлд тусгайлан авч үзжээ. Гадаад Монголын тусгаар тогтнолыг Өвөр Монголын олон ван гүнгүүд, 49 хошууны 35 (Монголын эрдэмтдийн судалгааг үндэслэн) нь дэмжиж, олон иргэд Ар Монголд ирснийг дурдав. Тэгвч Өвөр Монголын ван гүнгүүдийн олонх ДИУ-ын Засгийн газрын авсан амлалтын дараа түүний байр суурийг дэмжихээр шийдвэрлэсэн. Энэ нь Өвөр Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн бүх нутгийг хамраагүй, хядгаарлагдмал (21-р тал); ДИУ-ын Засгийн газар Өвөр Монголын ван гүнгүүдийн эрхийг баталгаажуулж, шарын шашин шүтэхийг хамгаалалд авсан (23-р тал) зэрэгтэй холбоотой юм; түүний хамт Өвөр Монголын ноёд Орос Монголын хооронд байгуулсан хэлэлцээрийг эсэргүүцэж, энэ талаар ДИУ-ын Засгийн газартай нэг байр суурьтай болсон байв гэж тэмдэглэжээ.

Судлаачийн хөндсөн нэг асуудал бол Ар Монголын цэрэг Өвөр Монголд дайлаар мордсон асуудал юм.

Судлаачийн бичсэнээр гурван замаар Өвөр Монголд оруулсан “Ар Монголын цэргүүд Өвөр Монголыг түйвээн бусниулсан нь Удайн хөдөлгөөнөөс хол давжээ” (23-р тал). ДИУ-ын цэрэг эхлээд ялагдал хүлээсэн бөгөөд нэмэгдэл хүч ирсний дараа Хүрээний цэрэгтэй амжилттай тулалдсан, 1913 оны эцэс гэхэд Хүрээний цэргийг бүрмөсөн хөөн зайлуулжээ (23-р тал) гээд энэ үйл явдалтай холбогдуулан зохиогч дүгнэн бичихдээ “Хүрээ ийнхүү Ар, Өвөр Монголыг цэргийн хүчээр нэгтгэх гэсэн оролдлого талаар болсон боловч Хятадаас өөрийнхөө тусгаарласныг тод томруун харуулж өгчээ” (23-р тал) гэсэн байна.

Энэ хэсэгт дурдсан зүйлс буюу Ар Монгол Орос улстай хэлэлцээр байгуулсан, Өвөр Монголыг цэргийн хүчээр нэгтгэх оролдлого хийж түүний явцад олон түмнийг түйвээн бусниулсан зэрэг нь Өвөр Монголын ард түмний дургүйцлийг хүргэж Ар Монголоос улам хөндийрүүлсэн гэж зохиогч дүгнэж байна.

Судлаачийн үзэж байгаагаар ийнхүү Өвөр Монголын ван гүн нарын хувьд монгол үзэл санаанд нь том еерчлөлт гарч, өмнө нь тэд монгол үндэстний хувьд Ар Монголтой нэгдэхийг хүсдэг байсан бол ДИУ-ын Засгийн газар амлалт авсны дараа Орос-Монголын гэрээг эсэргүүцэн, ДИУ-ын бүрэлдүүнд байхаар санаа шулуудсан (23-р тал) ажээ.

Зохиогч 1912 оны Орос-Монголын гэрээ, 1913 оны Хятад-Оросын тунхаглал, 1915 оны Хятад, Орос, Монголын хэлэлцээр зэргийн шийдвэрээс ишлэн гурван улсын хэлэлцээр ёсоор Ар Монголын тусгаар тогтнолыг албан ёсоор цуцалж, автономит Гадаад Монгол болгосныг дурдав.

Илтэлийнхээ төгсгөлд Гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөний зорилго нь яваандаа Ар, Өвөр Монголыг нэгтгэсэн нэгдсэн, тусгаар тогтносон Монгол улс байгуулах явдал болжээ. “Энэ нь нэгэн үндэстний хувьд зохих асуудал” боловч цаг үеийн нөхцөл байдлын улмаас “Монголын тусгаар тогтнол нь Өвөр Монголыг багтаасангүй”, Гурван улсын хэлэлцээрийн дараа “Өвөр Монголын тусгаар тогтнох боломж тас хаагдсан”. Харин Хятадын сулран доройтсон үед Ар Монгол Оросын тусламж дэмжлэг авсан. Ингээд “Ар Монгол Хятадаас улам улам холдон, Оростой улам улам ойртох болсон нь нэгэнт эргэлт буцалтгүй болсон байв” (26-р тал) гэжээ.

Өвөр Монгол тусгаар тогтнолын хөдөлгөөн эхлэхэд ямар нэг хэмжээгээр татагдан орсон ч Хятадтай дотно холбоотой байсан тул ДИУ-ын бүрэлдүүнд үлдсэн.

Ар Монгол коммунистуудын нөлөөгөөр Хятадаас салан тусгаар тогтнов.

Өвөр, Ар Монголын ялгаа улам тодорч, эдийн засгийн харилцаа тасарсан.

Ар, Өвөр Монголын ард түмэн тус тусын замаа хөөж, нэгдмэл үндэстний шинж алдагдав.

Ар, Өвөр монголчууд ...дэлхий дахинд шинээр гарч ирсэн дэлхийн эдийн засгийн хувиарлалт, нөлөөний хүрээгээ тодорхойлох гэсэн хүчнүүдийн бодлогын улмаас хуваагдаж өөр өөр улсын үзэл санаатай болж одоог хүрчээ гэж Хуан Лишэн дүгнэн бичжээ.

Хятадын соёлын их сургуулийн улс төрийн бодлогын хүрээлэнгийн докторант Чэнь Вэйсинь “Манжаас Хүрээнд явуулсан шинэ засгийн бодлого, түүний ялагдлын шалтгааныг шинжлэхүй”

илтгэлдээ хар тамхины дайны дараа үеэс гадаадын их гүрнүүдийн түрэмгийллийг эсэргүүцэх, Манж Чин улсын хоцрогдлыг давж туулах зорилгоор Манжийн төрөөс явуулсан “шинэ засгийн бодлогыг” (ШЗБ) Монголд хүчтэй нэвтрүүлсэн асуудлыг авч үзсэн байна.

Тэрбээр хуучин тогтолцоог халж, улс орныг шинэчилэх гэсэн шинэ засгийн бодлого нь мөрөөдөл байв; энэ бодлого нь хуурамч шинжтэй бөгөөд Монголд чиглэсэн агуулгагүй, түүний хөгжилд өчүүхэн ч нэмэр болоогүй гэж үздэг зарим судлаачдын бодол санаанд шүүмжлэлтэй хандаад “шинэ засгийн бодлого гэгчийг Монголд нэвтрүүлсэн нь бодит байдалд нийцсэн шударга байх нь зүйтэй байсныг архивын түүх бичиг сэлтэд тэмдэглэсэн байх” (2-р тал) учир энэ асуудлыг цааш нарийвчлан судлах шаардлага бий гээд энэ талаарх өөрийн бодол санаагаа дэлгэрэнгүй гаргажээ.

Тэр илтгэлдээ шинэ засгийн бодлогыг хэрэгжүүлэх явцад Монголын төрийн захиргааны бүтэц, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн өөрчлөлт, энэ талаар дэвшүүлж байсан төсөл, монгол язгууртны төлөөлөгчдийн (Өвөр Монголын) дэмжлэг, их гүрнүүд, ялангуяа Орос улсын түрэмгий ажиллагаа, Хүрээнд байсан Манж амбан Янь Жи, Сандо нарын үйл ажиллагаа зэргийн талаар нэн дэлгэрэнгүй өгүүлжээ.

Шинэ засгийн бодлого Монголд яаж нөлөөлсөн бэ гээд бичихдээ: “Манжийн төрөөс Монголд нэвтрүүлсэн шинэ засгийн бодлого нь Монгол нутгийг хөгжүүлэн урагшлуулж, Монголын нийгмийн дэвшилд зохих хэмжээний ач холбогдолтой... Ялангуяа Монгол нутагт улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, үйлдвэр, худалдаа зэрэгт олон талаар гүнзгий нөлөө үзүүлсэн гэж болох юм” (25-р тал) гэж дүгнэжээ.

Зохиогч ШЗБ-ын эерэг талыг дараах байдлаар тодорхойлжээ.

1. Хүчирхэг хөрш (Орос улс)-ийн өнгөлзөлгийг эсэргүүцэж, хил хязгаарыг бэхжүүлэх зорилготой байсан. ШЗБ хэрэгжүүлснээр “бүх л байдал, урьдынхаасаа дэвшилттэй болсон” (25-р тал) гэж үнэлэв.

2. Аж үйлдвэржүүлж, хязгаар нутгийн эдийн засгийн хөгжлийг урагшлуулах, Манж гүрний сан хөмрөгийг доройтлоос аврах байсан. Тэгээд газар хагалбарлах ажлаас ихээхэн хэмжээний лан мөнгөний ашиг олсон, үйлдвэрүүд байгуулж, ачааг авто замаар тээвэрлэх болов. (26-р тал).

3. Хүн амын хөдөлгөөнийг зохицуулж үндэстэн нарын харилцан ойртох, нийлэн нэгдэхэд хэрэгтэй байв. Дотоодын хүн амын илүүдлийг идэвхтэй зохицуулж, хүн амыг нягтарсан бүсээс сийрэг нутаг руу шилжүүлсэн.

4. Гэрлэлтийг урамшуулж, боловсролыг хөгжүүлж, монгол нутагт улс төрийн тогтвортой байдлыг хангасан. “Монголд хань

үндэстний тариачид монгол үндэстнийг түшиглэж, монгол хэл сурч, монгол заншил дагаж, монголын харьяат болж, монгол хүүхэнтэй гэрлэвэл хань үндэстний хүн монгол нийгэмд нэгдэн нийлж монгол хятад холилдон суух хэлбэршлийн илэрхийлэл болох юм” (28-р тал).

“Энэ бүхэн Монгол газарт улс төр тогтворжих, эдийн засаг, соёлын хөгжилд туслах хүчин зүйл...” болох байсан юм гэх мэтээр илтгэгч дүгнэжээ.

Судлаач бичихдээ ШЗБ-ыг хэрэгжүүлснээр амжилт ололтын зэрэгцээ ноцтой асуудлууд бий болсон гэжээ. Энэ арга хэмжээний сөрөг тал судлаачийнхаар бол дараах хоёр зүйл ажээ.

1.“Манжийн төр гадаадын худалдаачдад Монголд уурхай нээхийг зөвшөөрсөн, ШЗБ-аас болж түшмэд, иргэд уурхай эрхлэн нээх болсон зэрэг нь сөрөг талтай” (29-р тал). Монголд уурхай нээх ажил нь бүхэлдээ гадаадын хөрөнгөтний ноёрхолд орсон.

2.“Гадаадын банк орж ирж, Манж Чин улсын банкны байр суурийг орлож, монголын нийгэм-эдийн засагт хязгаарлал тогтоов” гэсэн энэ хоёр сөрөг талтай ажээ.

Монголд явуулсан ШЗБ-ын ялагдлыг судлаач шинжлээд дараах 4 шалтгаанаас болсон гэж үзжээ. Үүнд:

1.Манжийн төрийн санхүү улайсанаас хөрөнгө оруулалтын эх үүсвэр хангалтгүй байсан явдал.

2.“Гадаадын хөрөнгө мөнгө монголын үндэсний гар үйлдвэрийн барааны хөгжилд” ноцтой цохилт өгсөн явдал.

3.Орос улсын өнгөлзлөгө идэвхжсэн явдал. ШЗБ эхлэхээсээ аваад Оросын зүй бус өнгөлзлөгөтэй тулгарч байв. Оросоос Монголд булаан дээрэмдэх ажил явууллагад нь ШЗБ саад болж байсан юм гээд Монгол дахь ШЗБ-ын талаар Хятад Оросын хооронд солилцож байсан бичиг баримтын талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байна. (32-35-р тал).

4.Монголын ван гүн, язгууртнууд энэ бодлогод эмзэглэн эсэргүүцсэн явдал. ШЗБ хэрэгжүүлэх олон тооны байгууллага байгуулагдаж их зардал шаардсан, ноёдын эрх дархад халдсан, урамшууллын систем алга болсон, монгол дахь засаг захиргааг хятад түшмэд шууд гардан явуулах болсноос ШЗБ-ыг эсэргүүцэн тэмцэж эхэлсэн гэжээ.

Чэнь Вэйсинь илтгэлийнхээ төгсгөлд: “..Сайн санаа гаргаж Манжийн төрийн түшмэдүүд Монголын бүх давхрагын хэмжээнд нэвтрүүлсэн төрөл бүрийн арга хэмжээ болон шинэ маягийн үйлдвэр аж ахуйн газрууд нь Монголын нийгэмд шинэ соёлын уур амьсгалыг авчирч, Монголын бүх салбарыг нээж, Монгол дахь шинэчлэлтэнд ихээхэн ашиг тусаа өгсөн юм. Хэрэв Монгол газар шинэ засгийн бодлогыг жинхэнэ ёсоор хэрэгжүүлэх арга хэмжээ авч явуулсан бол

Монголын ард түмэнд ашигтай байх байсан юм”. “Угтаа шинэ засгийн бодлого буруугүй байсан” бөгөөд харин энэ бодлогыг хэрэгжүүлж байсан Манжийн Засгийн газар монголын нийгмийн эрэлт хэрэгцээг ойлгож, нийгмийн салбаруудад гүнзгий өөрчлөлт хийгээгүй... монголчуудыг орчин үе рүү нь чиглүүлж чадаагүй юм. Манжийн төр баригчид ШЗБ хэрэгжүүлэхэд ялагдсанаар тэдний төр барих эрх түүхийн урсгалд бүрмөсөн устаж үгүй болоход хүргэсэн гэж дүгнэсэн байна.

Хятадын соёлын их сургуулийн Улс төрийн хүрээлэнгийн дэд профессор Лю Сюеяо “Автономиос автономия алдах хүртэл” илтгэлийнхээ товчлолд Гадаад Монгол 1911 онд тусгаар тогтнолоо зарласнаас 1915 оны гурван улсын гэрээгээр тусгаар тогтнолоо алдаж автономит гадаад Монгол болох хүртлэх үйл явдлыг дурдаж, Автономит Гадаад Монгол ДИУ-ын харилцаа, Монголын автономийг устгах талаар Хятадын Засгийн газрын үйл ажиллагааг цөөн үгээр илэрхийлсэн байна.

1915 оны 6-р сарын 14-нд Бээжингийн умартын цэргийн засгийн газар Чэнь Луг Хүрээнд суух анхны элчээр, Чэнь И, Лю Чунхуй, Чянь Куйзэн нарыг Улиастай, Ховд, Хиагтад суух туслах элчээр томилсон гээд 1916 оны 8-р сараас 1919 он хүртэл хугацаанд Чэнь И-г тэргүүн элчээр томилон ажиллуулсныг дурьдав. Дурьдсан хоёр элч “хил хязгаарын асуудлыг явуулахдаа тэвчээртэй аядуу байхыг ойлгож”, Гадаад Монголын “ноёд, лам нартай ойртон нийлж”, Гадаад Монголын “дээд хүрээнийхний итгэлийг” хүлээснийг онцлов.

Энэ үед /1919/ монголчууд Орост болсон улаан намын хувьсгал болон Нармай Монголын хөдөлгөөнөөс эмээж байсныг Чэнь И даруй ашиглан “автономия устгаж” “төвийн хамгаалтанд орох” нь хамгийн дөхөмтэй арга гэж үзснийг “Гадаад Монголын дээд хүрээнийхэн хүлээн авсан”. Энэ үндсэн дээр хоёр тал эвийн байдал “автономия устгах” хэлэлцээр байгуулах нь “Монголын асуудлыг амжилттай дуусгах” сайн арга гэж Чэнь И үзээд тэвчээр гаргаж байсныг зохиогч тэмдэглэв.

Гэвч Бээжингийн эрх баригчид Сюй Шужаныг Баруун хойд хязгаарын элчээр томилж, цэрэг удирдуулан Монголд оруулсныг зохиогч “санаанд ороогүй явдал” гэж үзэв. Зохиогчийн үнэлгээгээр Сюй Шужан “хязгаарын үндэстний асуудлыг хэрхэн шийдэх талаар огт мэдлэггүй”, “тэдний ёс заншлыг үл хүндэтгэдэг” аж. Тэрбээр, зохиогчийн бичснээр, Чэнь И болон Гадаад Монголын эрх баригчдын хооронд боловсруулсан “Гадаад Монголыг тохинуулах дүрэм” гэгчийг “огт хэрэггүй зүйл” хэмээн үзэж Жавзандамба хутагт ба бусад ноёдын өргөөг бүслэв. Цэргийн сүр хүчнээс айсан Гадаад Монголын эрх баригчид автономийг устгах албан бичигт үсэг зурж, 1919 оны 11-р

сарын 22-т албан ёсоор гардуулсан. “Автономит эрх олсон ба устахад ердөө 4 жил, 5 сар, 6 хоног орсон” байна гэж профессор бичсэн. Сүй Шужаны хэрэглэсэн арга нь үйл явцыг түргэвчилсэн боловч “Гадаад Монголын ард түмнийг өргөмжлөн хүндэтгэх сэтгэлийг шархлуулан, Монгол, Хятадын үндэстний эв эед хар сүүдэр авчирсан” гэж Сүй Шужаны үйл ажиллагааг зохиогч үнэлэв.

Тайваний судалгааны төв академийн Шинэ түүхийн хүрээлэнгийн проф. Жан Жисюн “Нармай Монголыг байгуулах гэсэн хөдөлгөөн: Халхын тусгаар тогтнолын талаархи өөр үзэл” илтгэлдээ Халхын тусгаар тогтнолын хөдөлгөөн дан ганц Гадаад Монголын хөдөлгөөн үү эсвэл Халхаар төвлөрсөн монгол үндэстнийг нэгтгэх хөдөлгөөн үү, Халхын тусгаар тогтнол ба Нармай Монголын хөдөлгөөн хоорондоо ямар холбоотой вэ гэсэн асуудал тавиад өөрийнхөөрөө хариулах оролдлого хийжээ.

Тэрбээр Халхын тусгаар тогтнох хөдөлгөөн нь Гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн гэдгийг судлаачид тогтоосон юм гээд өөрөө Халхын тусгаар тогтнолын хөдөлгөөн нь зөвхөн Гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн биш, Нармай Монгол үндэстний улсыг нэгтгэх хөдөлгөөн юм гэж үзжээ.

Судлаач бичихдээ энэ хөдөлгөөн нь “эхнээсээ аваад эцсээ хүртэл маш сайн төлөвлөсөн стратегийн төлөвлөгөө” юм, энэ хөдөлгөөн бол “түр зуурын сэтгэлийн хөдөлгөөнөөр үүссэн бус, харин тохиолдлыг урьдчилан тааж өөрчилсний үр дүн байсан” (2-р тал) гэсэн дүгнэлт хийжээ. Түүний хамт Гадаад Монголыг тусгаар тогтноулж, Их Монгол улсыг байгуулах зорилготой байсан ч энэ талаар “өөрийн бэлтгэсэн байвал зохих бодит хүчин чадал, чадвар, өөрийгөө танин мэдэхийн хувьд дутмаг байсан”, ийм учраас ч зорилгодоо хүрч чадахгүй гэдгийг ойлгож байсан гэжээ.

Тэгээд зохиогч илтгэлдээ “түүхийн материалыг гүйцэд сайн задлан шинжилж, Халхын тусгаар тогтнол нь Гадаад Монголын тусгаар тогтнолын ойрын зорилт, Нармай Монголыг нэгтгэх нь холын зорилт юм гэдгийг явцуу болон өргөн утгаар авч” үзэхийг оролдсон гэжээ.

Зохиогч асуудлын явцуу утга гэдгийн хүрээнд 1911 оны 7-р сарын 10-нд нууц зөвлөлгөөн болсон; монголчууд Манжийн Засгийн газраас хэрэгжүүлсэн шинэ Засгийн бодлого, харгис боолчлолоос эмээсэн; тусламж хүсэх зорилгоор өөрсдийн төлөөлөгчдийг Орост илгээсэн; 1911 оны 11-р сарын 30-нд (товчлол, 2-р тал) Богд Жавзандамбыг Хаанд өргөмжилж, Монголын тусгаар тогтнолыг зарласан; Өвөр, Ар Монголын олон аймаг хошуудад уриалга гаргасан зэрэг түүхэн үйл явдлуудыг хамруулж байна. Харин зорилгын өргөн утга гэдгийг Халхын тусгаар тогтнолын явцад Халхыг “төр шашны төв болгох, гадаад бодлогыг зохицуулах, цэрэг зэвсгийн хүчийг

зузаатгах” оролдлого алхам газар сайгүй гарч байсан; хутагтыг хаан гэж шүтэн төв Засгийн газар байгуулж, төрийн бодлого явуулах, нармай Монголыг байгуулах эрх бүхий байгууллага бий болгосон; зүүн баруун өмнөд Монголд элч илгээж уриалгыг сурталчилах, Монголыг нэгтгэх хэрэг явдлыг зарлах зэргээр Өвөр Монголыг зохицуулах өдөөлгө хийж, хойд Монгол (Оросын хил доторхи буриад монгол)-д уриалга гаргаж, “Их Монголын хаант улс” байгуулахыг санаархан байсан зэргийг зохиогч оруулж (товчлол, 2-р тал) байх шиг байна.

Зохиогч Халх Монгол өөрийн стратегийн төлөвлөгөө ёсоор ямар алхамууд хийсэн, тэдгээрийн явц, үр дүн ямар байсныг Халх Монголын тусгаар тогтнол, тусгаар тогтнолын талаархи Орос Монголын маргаан, Улиастай болон Ховдыг нэгтгэсэн нь, Өвөр Монгол руу цэрэг илгээсэн нь гэсэн дөрвөн хэсэгт хуваан нэгэнт тодорхой түүхийн баримтуудыг ашиглаж бичсэн байна.

Эдгээр хэсгүүдэд гаргасан зарим үзэл бодол, санаа дүгнэлтүүдээс дурьдвал

1911 оны 7-р сарын 10-ны нууц зөвлөлгөөнд феодал эзэд, том лам 18 хүн оролцсон, Хэлэлцэхээр төлөвлөсөн асуудал нь газар хагалбарлах, Жанчихүү Хүрээний хооронд төмөр зам байгуулах асуудал байсан ч хэрэг дээр тусгаар тогтнолыг эрэлхийлэх асуудал байсан. Зөвлөлгөөнийг албан яам, ой мод, орос цагаач иргэдийн гэрт хийсэн. Зөвлөлгөөн 7-р сарын 30-нд өндөрлөсөн.

Зөвлөлгөөн, түүний бичсэнээр, Жавзандамбын удирдлагаар тусгаар тогтноход бэлтгэх дэс дараатай ажлууд төлөвлөсөн. Үүнд: нэгд, Оросоос дипломат, цэрэг-эдийн засгийн тусламж хүсэх, хоёрт, Орос улсын дэмжлэг тусламжтайгаар тусгаар тогтнолыг зарлах, гуравт, Маймаачин, Улиастай, Ховдыг эзэлж газар нутгаа бэхжүүлэх, дөрөвт, Өвөр Монголыг ятаж, Хүрээг дагахыг уриалах ба цэрэг хувиарлан илгээх, хятад цэрэгтэй тулалдах үед Оростой холбоотойгоор байлдааны асуудал шийдэх (5-р тал) гэж тогтсон гэжээ.

Зөвлөлгөөний үеэр Жавзандамбын нэрээр Орост захидал бичиж, тэнд “Монгол “Улс” Хаант Оросын хамгаалалд орохоо илэрхийлсэн” гээд хуралдагсад уг захидалд гарын үсэг зурсан, Ханддоржийг Жавзандамбын Гадаад хэргийн сайд нэрээр төлөөлөгчдийг толгойлуулсан, хуралдааны шийдвэрийг Оросын консулд мэдэгдсэн гэжээ.

7-р сарын 29-нд Жавзандамбын зарлигаар Орост илгээх төлөөлөгчдийг баталж, бүрэлдүүнд нь Хайсан гүнг оруулсан. Энэ нь “Өвөр Монголын ван гүн нарыг түүгээр төлөөлүүлж, Монголын язгууртан нар Манжаас салж, Өмнөд Монголыг багтаасан Их Монгол улсыг байгуулахын эхлэл” (5-р тал) гэж харуулах оролдлого юм гэжээ.

Судлаач Жавзандамба нарын хүмүүс тусгаар тогтнохыг оролдож Хятадаас салж Оросыг гуйх үйл ажиллагаа бол “үнэндээ Хаант Оросын эзэрхэг түрэмгийчүүдээс үүдэлтэй бөгөөд урт удаан хугацаанаа явуулсан хуйвалдааны шууд хор уршиг байлаа. Үүнийг Хаант Оросын Засгийн газар нуулгүй шууд хэлслэн байдаг” (6-р тал) гээд “үнэндээ Монголын асуудлаар гарсан хямрал нь бидний бодлоос гараагүй, эртнээс нааш манай улс монголчуудыг ямагт дэмжиж өмөөрч ирсэн” (6-р тал) гэсэн дүгнэлт хийж байна.

Монголын ван гүнгүүд Манжийн шинэ засгийн бодлогоос онцгой айн сандарсан. Энэ бодлого бол Монголыг колончилох бодлого гэж үзсэн. Яг ийм үед Оросын Засгийн газар Монголд зовлонгүй орж, өөрийн төлөөлөгчиддөө “Хятад Монголыг хагалан бутраах бодлого явуулж” “монголчуудыг дэмжиж өмөөрөх” арга барил ашиглахыг зөвлөсөн. Монголчуудын дунд “хятадаас харилцаа таслахад Орос улсын тусламжийг олох болно” гэсэн итгэл үнэмшлийг төрүүлсэн, Гадаад Монголын ван, гүнгүүд Орос улсаас тусламж авахыг бодолхийлж эхэлсэн гэж судлаач үзэж байна. “Орос улсын оролцолгоо зуучлал Хятад Монголын эзэн харьяатын харилцааны хямралыг дэлбэлж Монголын хэрэг явдлыг улам төвөгтэй болгосон” гээд Хүрээ-Петербург, Петербург-Бээжингийн хооронд явагдсан яриа хэлэлцээ зэргийг тодорхой бичжээ. (6-10-р тал).

Монголчуудын өрнүүлсэн Халхын тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөний эцсийн зорилго нь Нармай Монголыг байгуулах явдал байсан бөгөөд энэ нь тэдний “үзэл ухамсраараа хийх гэсэн зохион байгуулалттай үйл ажиллагаа” байсан юм гэж зохиогч үзжээ. Тиймээс энэ асуудал нь 1912 оны сүүлчээр Монгол-Оросын хооронд болсон хэлэлцээний үеэр хурц маргааныг төрүүлсэн гэж судлаач тэмдэглээд түүнийг дэлгэрэнгүй задлан үзжээ. Хэлэлцээний өмнө Монголын төлөөлөгчид “Монголын тусгаар тогтнолд Өвөр Монгол нэгдэж “нэгэн гэр бүл болох” хүсэлтэй байгааг” онцлон тэмдэглэсэн; Оросын тал үүнд хариу болгон энэ уулзалтаар “Зөвхөн Гадаад Монгол буюу Халхын асуудал хэлэлцэнэ. Өвөр Монголын асуудлыг...гарган тавьж болохгүй” гэсэн байр сууриуд болон хэлэлцэгч талуудын дэвшүүлсэн хэлэлцээрийн төслүүдийг тойрон маргаан явагдсаныг тэмдэглэжээ. Эцэст судлаач “Хэрэв бүх Монголыг нэгтгэнэ хэмээн хүсч байгаа бол хятадтай төдийгүй Оростой дайтах болно” гэсэн Оросын төлөөлөгчийн үгийг иш татан, Монголын хүсэлтийг Орос хүлээн авч дэмжээгүй гэж дүгнэсэн байна.

Гадаад Монгол болон Нармай Монголыг нэгтгэх асуудлыг судлаач тусгайлан авч үзсэн байна. Тэр бичихдээ “Синьхайн хувьсгалын үеийн Гадаад Монгол сая тусгаар тогтнолоо зарлаж Хүрээний засгийн газар байгуулж, хүмүүсээ илгээн Наймаа хотыг

авснаар Оросын цэрэгтэй нэгдэн Улиастай, Ховд руу, нийт Гадаад Монголын нутаг руу нэвтрэн орж харьяалалдаа авсан...Ийнхүү нийт Гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн дуусгавар болов” (19-р тал) гэж үзжээ.

Өвөр Монголын тухай бичихдээ:

-Өвөр Монголыг нэгтгэх тухай олонтоо бичгээр шаардсан.

-Хөлөнбуйр 1912 оны 4-р сард Жавзандамба Хутагт хааны бичиг авч Монгол улсын нэг хэсэг болсон (3-р тал) боловч 1912 оны 10-р сард Дорнод Монголын ван гүнгүүд Жавзандамбын бичгийг авсны дараа анх удаа Гадаад Монголоос татгалзаж байгааг мэдэгдэн Бүгд Найрамдах Улсын хамгаалалд орсноо илэрхийлсэн (20-р тал). Тэд 1913 оны 10-р сард хоёрдах удаагаа хуралдаж Хүрээний тусгаар тогтнол ба Оросын түрэмгийллийг эсэргүүцсэн шийдвэр гаргасан.

-1912 оны өвөл Монгол цэрэг Дотоод Монголын бүх нутагт довтолон орсон.Хятадын засгийн газар монгол цэргийн довтолгооныг эсэргүүцэхийг орон нутагт суугаа сэргийлэн хамгаалах цэргийнхэнд даалгасан; Дипломат аргаар Оросын талтай хамтран ажилласан; Гадаад Монголын цэргийн хүчээр Нармай Монголыг байгуулах гэсэн төлөвлөгөөг таслан зогсоох арга хэмжээ авсан (20-р тал).

-Орос улс Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөгүй, Өвөр Монголыг хамгаалалдаа авахыг татгалзсанаар Өвөр Монголыг нэгтгэх гэсэн улс төрийн хууль ёсны үндэс суурь нь нурсан (3-р тал).

Иймэрхүү хүчин зүйлсийн нөлөөгөөр монгол үндэстнийг нэгтгэх гэсэн Гадаад Монголын төлөөлөгөө нь хоосон зүйл болсон (3-р тал) гэж Жан Жисюн бичиж байна.

1913 онд гаргасан Орос Хятадын тунхагийн үндсэн дээр 1915 онд Хиагтад болсон Хятад, Орос, Монгол гурван улсын хэлэлцээрээр “Монгол улсын цолыг хүчингүй болгож, Гадаад Монголын автономит Засгийг байгуулж, Жавзандамба хааны цолыг устгаж, Гадаад Монголын Богд Жавзандамба хутагт хаан хэмээн еерчилж, Дундад иргэн улсын Да Жунтаны илгээмж бичгийг авах, оны цолыг еерчлөн Иргэн улсын оныг хэрэглэх болсон боловч Монголын 12 жилийн оныг давхар хэрэглэх болсон” гээд “энэ үеэс эхлэн Гадаад Монгол нь бүх Монголыг нэгтгэх, ...Монгол улсын байр суурийг хамгаалах ч аргагүй болсон төдийгүй Төв Засгийн газрын нэрийг хэрэглэхийг хориглосон байна. Гадаад Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн ба Нармай Монголыг нэгтгэх хөдөлгөөн нь эцэстээ ялагдалд хүрсэн” (22-р тал) гэжээ.

Гурван улсын хэлэлцээрээр Монголд тогтоосон автономийг Чжан Чжи Сюн үнэлэхдээ энэ бол “Оросын хувьд “улс дундын” автономит эрх болохоос биш, барууны орнуудых шиг “бүрэн эрхт тусгаар тогтносон” улсын төлөв байдалтай адилгүй байлаа” (22-р тал)

гэжээ.

Зохиогч илтгэлдээ:

-Жавзандамбын гаргасан уриалах бичгээс иш татан Монголын тусгаар тогтнолын шалтгаан нь “газар нутгаа, шашныг хамгаалахад” ... оршиж байсан гэж үзэж болох юм” (12-р тал)

-Халхыг нэгтгээд, нармай монгол үндэстний хөдөлгөөнийг аажмаар өргөжүүлсэн нь нэгэн үндэстний тусгаар тогтнолын хөдөлгөөн бүхий л үндэстнийг нэгтгэх чиглэлийг бадруулж болно гэдгийг харуулав.(Товчлол, 4-р тал)гэсэн дүгнэлтүүд хийсэн байна.

Эцэст нь зохиогч өөрийн илтгэлийн сэдвийн дагуу дүгнэхдээ:

-Халхын тусгаар тогтнол бол зөвхөн Гадаад Монголыг нэгтгэх хөдөлгөөн; -Энэ нь зөвхөн үзэл бодлын хувьд төдийгүй үйл ажиллагааны хувьд Нармай Монголыг нэгтгэх хөдөлгөөн; -Халхын тусгаар тогтнолын хөдөлгөөн бол Нармай Монголыг нэгтгэх хөдөлгөөний эхний шат, харин Нармай Монголыг байгуулах нь Халхын тусгаар тогтнолын хөдөлгөөний эцсийн шат юм гэж Жан Жисюн бичжээ.